



Монголбанк

Санхүүгийн мэдээллийн алба

**САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНД МЭДЭЭЛЭХ
ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДЭЭС ЦАХИМААР МЭДЭЭЛЭЛ
ИРҮҮЛЭХ ЖУРМЫН ДАГУУ ТАЙЛАН БӨГЛӨХ
ЗААВАР, ЗӨВЛӨМЖ**

МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭД | **ХУУЛЬЧ**

2020 он

АГУУЛГА

1. Холбогдох хууль, журам болон олон улсын стандарт.....	2
2. Тайлан ирүүлэх үндэслэл, шаардлага.....	2
3. Тайлан ирүүлэх хугацаа.....	3
4. Тайлан ирүүлэх арга, хэлбэр.....	3
5. Мэдээллийн нууцлалыг хадгалах.....	3
6. Нэмэлт тодруулга.....	3
Заавар 1. Сэжигтэй гүйлгээний тайлан бөглөх.....	4
Заавар 2. Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан бөглөх.....	9
Заавар 3. Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан бөглөх.....	15

1. Холбогдох хууль, журам болон олон улсын стандарт

ХУУЛЬЧ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор хуульд заасан гүйлгээний тухай мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэхдээ дараах хууль тогтоомж болон олон улсын стандартыг дагаж мөрдөнө. Үүнд:

- 1.1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль;
- 1.2. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль;
- 1.3. Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам (Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А-326 дугаар тушаалаар батлагдсан);
- 1.4. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам (Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А-21 дугаар тушаалаар батлагдсан);
- 1.5. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журам (Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 463 дугаар тогтоолоор батлагдсан)
- 1.6. ФАТФ-ын 40 Зөвлөмж - Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт

2. Тайлан ирүүлэх үндэслэл, шаардлага

2.1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д заасны дагуу хуульч нь өөрийн харилцагчтай холбоотой дараах ажиллагааг бэлтгэсэн, хийсэн эсхүл оролцсон бол уг хуулийн 7 дугаар зүйлд заасан гүйлгээний мэдээллийг Санхүүгийн мэдээллийн алба (СМА)-нд мэдээлэх үүрэгтэй. Үүнд:

1. үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах;
2. харилцагчийн хөрөнгийг удирдах;
3. банкны, хадгаламжийн, үнэт цаасны дансыг удирдах;
4. компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах;
5. хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, эсхүл хэлцлийн үндсэн дээр аливаа тодорхой үйл ажиллагаа явуулах, удирдах, эсхүл аж ахуйн нэгжийг худалдах, худалдан авах.

2.2. Сэжигтэй гүйлгээний тайлан: хуульч нь энэ заавар, зөвлөмжийн 2.1-д дурдсан ажиллагааг хийх явцдаа харилцагч/үйлчлүүлэгчийн хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол СМА-нд Сэжигтэй гүйлгээний тайлан (СГТ)-ийн маягтын дагуу мэдээлнэ.

2.3. Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан болон Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан: Хуульч нь энэ заавар, зөвлөмжийн 2.1-д дурдсан ажиллагааг хийх явцдаа харилцагч/үйлчлүүлэгчтэй холбоотой 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээ хийсэн бол СМА-нд Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан (БМГТ) болон Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан (ГТТГТ)-ийн маягтын дагуу мэдээлнэ.

3. Тайлан ирүүлэх хугацаа

3.1. Хуульч нь харилцагч/үйлчлүүлэгчийн хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ тухай 24 цагийн дотор мэдээлнэ.

3.2. Хуульч нь 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор мэдээлнэ.

4. Тайлан ирүүлэх арга, хэлбэр

4.1. Хуульч нь СМА-наас хүргүүлсэн тайлангийн маягтыг бөглөж, СМА-ны fiu@mongolbank.mn и-мэйл хаяг руу цахим шууданд хавсарган илгээнэ.

4.2. Тайлан илгээхдээ тайлангийн маягт бүхий файлыг нууц үгээр хамгаалж, нууцлал аюулгүй байдлыг хангана. Нууц үгийг СМА-ны хариуцсан ажилтанд утсаар мэдэгдэнэ.

4.3. Тайланг ирүүлэхдээ тайлангийн маягтыг энэ заавар, зөвлөмжийн дагуу бүрэн гүйцэд, үнэн зөв бөглөж мэдээлнэ.

5. Мэдээллийн нууцлалыг хадгалах

5.1. Хуульчид тайланд холбогдсон харилцагч/үйлчлүүлэгч, хувь хүн, хуулийн этгээдэд түүний тухай мэдээллийг бэлтгэсэн, мэдээлэх гэж байгаа эсхүл мэдээлсэн тухай мэдэгдэхийг хориглоно.

5.2. Хуульчид тайланг бэлтгэсэн, мэдээлэх гэж байгаа эсхүл мэдээлсэн тухай хуульд заасан эрх бүхий байгууллага, эрх бүхий албан тушаалтнаас өөр этгээдэд мэдээлэхийг хориглоно.

6. Нэмэлт тодруулга

Тайлангийн маягт бөглөх болон тайлан илгээхтэй холбоотой асууж, тодруулах зүйл гарвал Санхүүгийн мэдээллийн албатай холбогдоно уу.

Утас: 326161, 321199

Цахим шуудангийн хаяг: fiu@mongolbank.mn

Цахим хуудас: fiu.mongolbank.mn

ЗААВАР 1. СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН БӨГЛӨХ

Хуульч нь энэ заавар, зөвлөмжийн 2.1-д дурдсан ажиллагааг хийх явцдаа харилцагч/үйлчлүүлэгчийн хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол дараах зааврын дагуу Сэжигтэй гүйлгээний тайлангийн маягтыг бөглөж СМА-д хүргүүлнэ.

I. А ХЭСЭГ. Энэ хэсэгт сэжигтэй гүйлгээ/үйлдэл хийсэн, хийж байгаа, эсхүл хийхийг завдаж буй хувь хүн, хуулийн этгээдийн талаарх мэдээллийг бичнэ.

А ХЭСЭГ. Сэжигтэй Гүйлгээг Хийж Байгаа Этгээдийн Талаарх Мэдээлэл	Талбарын нэр	Тайлбар	Жишээ (Иргэн)	Жишээ (Хуулийн этгээд)
	1.Эцгийн нэр	Эцгийн нэр	Дорж	-
	2.Хувь хүн/ байгууллагын нэр*	Хувь хүний нэр / Хуулийн этгээдийн нэр	Бат	Эй Би Ви Жи ХХК
	3.Ургийн овог	Ургийн овог	Боржигон	-
	4.Бусад нэр	Харилцагч/үйлчлүүлэгчид Талбар 1-3-д бичсэнээс өөр бусад нэр байдаг бол эсхүл өөр нэр ашигладаг бол түүнийг бичнэ.	John Smith	ABVG LLC
	5.Төрсөн улс	Хувь хүн: төрсөн улс Хуулийн этгээд: үүсгэн байгуулагдсан улс Улс орны нэрийг “СМА-нд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам”-ын Хавсралт 4-т байгаа ISO 3166-1 Улс, орнуудын нэр болон түүний товчилсон тэмдэгтийн стандартын дагуу бичнэ.	MN	MN
	6.Харьяалал	Хувь хүн: харьяалагдаж байгаа улс Улс орны нэрийг “СМА-нд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам”-ын Хавсралт 4-т байгаа ISO 3166-1 Улс, орнуудын нэр болон түүний товчилсон тэмдэгтийн стандартын дагуу бичнэ.	MN	-
	7.Төрсөн огноо	Хувь хүн: төрсөн огноо Хуулийн этгээд: үүсгэн байгуулагдсан огноо Огноог Майкрософт Эксел (Microsoft Excel)-ийн “Date” форматаар бичнэ.	1970/05/01	1992/05/01
	8.Хүйс	Хувь хүний хүйсийг бичнэ.	Эр	-
	9.Биеийн байцаалтын төрөл (Гэрчилгээний	Сэжигтэй гүйлгээ/үйлдэл хийх үед ашигласан бичиг баримтын төрөл	Иргэний үнэмлэх	Улсын бүртгэлийн гэрчилгээ

төрөл)			
10.Биеийн байцаалтын дугаар (Гэрчилгээний дугаар)	Сэжигтэй гүйлгээ/үйлдэл хийх үед ашигласан бичиг баримтын дугаар	УБ0123456	9268987422
11.Регистрийн дугаар*	<p>Хувь хүн: Харилцагч/үйлчлүүлэгч нь Монгол Улсын иргэн бол түүний регистрийн дугаарыг, гадаадын иргэн бол түүний бичиг баримт дээрх регистрийн дугаар эсхүл бусад ижил төстэй дугаарыг бичнэ.</p> <p>Хуулийн этгээд: Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд бол түүний регистрийн дугаарыг, гадаад улсын хуулийн этгээд бол түүний бичиг баримт дээрх регистрийн дугаар эсхүл бусад ижил төстэй дугаарыг бичнэ.</p>	АБ70050100	5897635
12.Оршин суугаа хаяг	<p>Хувь хүн: Харилцагч / үйлчлүүлэгчийн оршин суугаа хаягийг бичих ба гадаадын түр оршин суугч бол Монгол Улсад түр оршин суугаа хаягийг бичнэ.</p> <p>Хуулийн этгээд: Хуулийн этгээдийн оршин байгаа газрын албан ёсны хаяг</p>	СБД, 1-р хороо, А хороолол, Б байр, 01 тоот	БЗД, 1 хороо, Улаанбаатар тауер 1-300 тоот
13.Утас	Харилцагч/үйлчлүүлэгчийн утасны дугаар (гэрийн утас, гар утас гэх мэт)	393939, 99000000	393939, 99000000
14.Эрхэлсэн ажил, мэргэжил, үйл ажиллагаа	<p>Хувь хүн: Харилцагч / үйлчлүүлэгчийн эрхэлж буй ажил, мэргэжил, үйл ажиллагааг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн албан хаагч, төрийн өмчийн эсхүл хувийн компанийн ажилтан бол эрхэлж буй албан тушаал, хувиараа аж ахуй эрхэлдэг бол ямар чиглэлийн аж ахуй, бизнес эрхэлдэг, ажилгүй бол “ажилгүй” эсхүл тэтгэвэрт, оюутан, группд гэх мэтээр бичнэ. - Гадаадын иргэн бол Монголд эрхэлж буй ажил, албан тушаал, бизнесийн үйл ажиллагааг бичнэ. <p>Хуулийн этгээд: Хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэл</p>	АБВ компанийн ерөнхий захирал	Мэдээллийн технологи

15.Ажлын газрын нэр, хаяг, утас	Хувь хүн: Харилцагч/үйлчлүүлэгчийн ажлын газрын нэр, хаяг, утасны дугаар	АБВГД ХХК, СБД, 1-р хороо, А байр, Б корпус Утас: 333333	-
---------------------------------	--	--	---

II. Б ХЭСЭГ. Энэ хэсэгт сэжигтэй гүйлгээ/үйлдэлд хамаарах дүн, огноо, хэрэв байгаа бол дансны мэдээллийг бичнэ.

Талбарын нэр	Тайлбар	Жишээ
16.Гүйлгээний нийт дүн *	Харилцагч/үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлж байх явцад сэжигтэй гэж үзсэн гүйлгээ, үйлдэлд хамаарах мөнгөн дүн	100,000,000.00
17.Гүйлгээ хийгдсэн огноо*	Сэжигтэй гүйлгээ/үйлдэл хийгдсэн огноо Огноог Майкрософт Эксел (Microsoft Excel)-ийн “Date” форматаар бичнэ.	2019/09/01
18.Валют*	Валютыг “СМА-нд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам”-ын Хавсралт 5-д байгаа ISO 4217 Улс, орнуудын мөнгөн тэмдэгтийн нэр болон түүний товчилсон тэмдэгтийн стандартын дагуу бичнэ.	MNT
19.Дансны дугаар	Сэжигтэй гүйлгээ/үйлдэлд холбогдох дансны дугаар	500400300100
20.Гүйлгээний утга	Сэжигтэй гүйлгээ/үйлдлийн утга	компани худалдан авах
21.Данс эзэмшигчийн бүтэн нэр	Энэ маягтын Талбар 19-д заасан дансны дугаар эзэмшигчийн бүтэн нэр	Доржийн Бат эсхүл АБВГ ХХК
22.Энэ гүйлгээнд оролцсон бусад банкны нэр, хаяг	Сэжигтэй гүйлгээ/үйлдэлд оролцсон бусад банкны нэр	ББ банк
23.Энэ гүйлгээнд оролцсон бусад дансны дугаар	Сэжигтэй гүйлгээ/үйлдэлд оролцсон бусад банкны дансны дугаар	300300300
24.Бусад банкин дахь данс эзэмшигчийн бүтэн нэр	Сэжигтэй гүйлгээ/үйлдэлд оролцсон бусад банкны данс эзэмшигчийн бүтэн нэр буюу хувь хүн бол овог нэр, хуулийн этгээд бол түүний оноосон нэрийг бичнэ.	Доржийн Бат эсхүл АБВГ ХХК

III. В ХЭСЭГ. Энэ хэсэгт гүйлгээ/үйлдэл, харилцагч/үйлчлүүлэгчийг Сэжигтэй гүйлгээний тайлангаар мэдээлэх болсон үндэслэл, тайлбарыг тодорхой, ойлгомжтой бичнэ.

В ХЭСЭГ. Сэжиглэх Үндэслэл	Талбарын нэр	Тайлбар	Жишээ
	25.Сэжиглэх үндэслэл*	Энд гүйлгээ/үйлдэл, харилцагч/үйлчлүүлэгчийг сэжиглэж буй үндэслэлийг тодорхой бичнэ. Хэрэв сэжиглэж буй гүйлгээ/үйлдэл эсхүл харилцагч/ үйлчлүүлэгч нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад төрлийн суурь гэмт хэрэгтэй холбоотой байна гэж үзвэл энэ тухай мэдээллийг мөн энд бичиж болно.	Үйл ажиллагаа явуулдаггүй компанийг хэт өндөр үнээр худалдан авсан.
26.Тайлбар*	Энд сэжигтэй гүйлгээ/үйлдэлтэй холбоотой болсон үйл явдал, хийгдсэн үйлдэл, үүссэн нөхцөл байдлын талаар буюу хэн юуг хэзээ хаана яаж хийсэн талаар товч бөгөөд тодорхой тайлбарлаж, хуульч яагаад уг гүйлгээ/үйлдэл, харилцагч/үйлчлүүлэгчийг сэжигтэй гэж үзэж байгаа талаар аль болох дэлгэрэнгүй бичнэ.	Иргэн А иргэн Б-ээс оффшор бүсэд үүсгэн байгуулагдсан, үйл ажиллагаа явуулдаггүй компанийг хэт өндөр үнээр худалдан авсан.	

IV. Г ХЭСЭГ. Энэ хэсэгт Сэжигтэй гүйлгээний тайлан бэлтгэсэн мэдээлэх үүрэгтэй этгээд буюу Хуульчийн талаарх мэдээллийг бичнэ.

Г ХЭСЭГ. Гүйлгээтэй холбоотой нэмэлт мэдээлэл	Талбарын нэр	Тайлбар	Жишээ
	27.Мэдээлэх үүрэгтэй этгээдийн нэр*	Гүйлгээ/үйлдлийг мэдээлж байгаа хуульчийн нэрийг бичнэ.	Нарансаран.Г
	28.Хаяг *	Мэдээлэх үүрэгтэй этгээдийн төрлийг бичнэ	Хуульч
	29.Гэрчилгээний дугаар*	Хуульчийн гэрчилгээний дугаар (Тамганы дугаар)	123456789
	30.Энэхүү тайланг бэлтгэсэн ажилтны овог, нэр*	Энэ маягтын Талбар 27-д заасан Мэдээлэх үүрэгтэй этгээдийн нэртэй ижил бичнэ.	Нарансаран.Г
	31.Албан тушаал*	Энэ маягтын Талбар 28-д заасан Мэдээлэх үүрэгтэй этгээдийн төрөлтэй ижил бичнэ.	Хуульч
	32.Тайланг хянасан ажилтны овог, нэр*	Энэ маягтын Талбар 27-д заасан Мэдээлэх үүрэгтэй этгээдийн нэртэй ижил бичнэ.	Нарансаран.Г
	33.Албан тушаал*	Энэ маягтын Талбар 28-д заасан Мэдээлэх үүрэгтэй этгээдийн төрөлтэй ижил бичнэ.	Хуульч
	34.Холбоо барих утас*	Мэдээлэх үүрэгтэй этгээдтэй холбоо барих утас, дотуур утасны дугаар	333333 (123)
	35.Э-мэйл хаяг*	Мэдээлэх үүрэгтэй этгээдийн и-мэйл хаяг	tsetsgee@abank.mn
36.Тайланг бэлтгэсэн огноо*	Огноог Майкрософт Эксел (Microsoft Excel)-ийн "Date" форматаар бичнэ.	2020/01/01	

ТАЙЛБАР: Сэжигтэй гүйлгээний тайлангийн маягт дахь * тэмдэглэгээтэй талбарыг заавал бөглөх шаардлагатай. Хэрэв хуульчид *-оор тэмдэглэснээс бусад талбарын мэдээлэл байгаа бол тухайн мэдээллийг бүрэн бөглөж, байхгүй бол хоосон орхино.

ЗААВАР 2. БЭЛЭН МӨНГӨНИЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН БӨГЛӨХ

Хуульч нь энэ заавар, зөвлөмжийн 2.1-д дурдсан ажиллагааг хийх явцдаа харилцагч/үйлчлүүлэгчтэй холбоотой 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн бол дараах зааврын дагуу Бэлэн мөнгөний гүйлгээний тайлангийн маягтыг бөглөж СМА-д хүргүүлнэ.

I. А ХЭСЭГ. Энэ хэсэгт 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн харилцагч/үйлчлүүлэгчийн мэдээллийг бичнэ. Харилцагч/үйлчлүүлэгч өөрийн нэрээр гүйлгээ хийж байгаа бол зөвхөн А Хэсгийг бөглөнө.

Харин харилцагч/үйлчлүүлэгч өөр хүний эсхүл байгууллагын нэрийн өмнөөс гүйлгээ хийж байгаа бол төлөөлсөн харилцагч/үйлчлүүлэгчийн мэдээллийг А Хэсэгт, төлөөлүүлсэн этгээдийн мэдээллийг Б Хэсэгт тус тус бөглөнө.

А ХЭСЭГ. Бэлэн мөнгөний гүйлгээ хийж байгаа этгээдийн мэдээлэл	Талбарын нэр	Тайлбар	Жишээ (Иргэн)	Жишээ (Хуулийн этгээд)
	1.Эцгийн нэр	Эцгийн нэр	Дорж	-
	2.Өөрийн нэр*	Хувь хүний нэр	Сарантуяа	-
	3.Ургийн овог	Ургийн овог	Боржигон	-
	4.Бусад нэр	Харилцагч/үйлчлүүлэгчид 1-3-д бичсэнээс өөр бусад нэр байдаг бол эсхүл өөр нэр ашигладаг бол түүнийг бичнэ.	Сара	-
	5.Төрсөн улс	Хувь хүн: төрсөн улс Улс орны нэрийг “СМА-нд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам”-ын Хавсралт 4-т байгаа ISO 3166-1 Улс, орнуудын нэр болон түүний товчилсон тэмдэгтийн стандартын дагуу бичнэ.	MN	-
	6.Харьяалал	Хувь хүн: харьяалагдаж байгаа улс Улс орны нэрийг “СМА-нд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам”-ын Хавсралт 4-т байгаа ISO 3166-1 Улс, орнуудын нэр болон түүний товчилсон тэмдэгтийн стандартын дагуу бичнэ.	MN	-
	7.Төрсөн огноо	Хувь хүн: төрсөн огноо Огноог Майкрософт Эксел (Microsoft Excel)-ийн “Date” форматаар бичнэ.	1970/05/01	-
	8.Биеийн байцаалтын төрөл	Гүйлгээ хийх үед ашигласан бичиг баримтын төрөл	Иргэний үнэмлэх	-
9.Биеийн байцаалт дугаар	Гүйлгээ хийх үед ашигласан бичиг баримтын дугаар	УБ0123456	-	

10.Регистрийн дугаар*	Хувь хүн: Харилцагч/үйлчлүүлэгч нь Монгол Улсын иргэн бол түүний регистрийн дугаарыг, гадаадын иргэн бол түүний бичиг баримт дээрх регистрийн дугаар эсхүл бусад ижил төстэй дугаарыг бичнэ.	АБ70050100	-
11.Оршин суугаа хаяг	Хувь хүн: Харилцагч/үйлчлүүлэгчийн оршин суугаа хаягийг бичих ба гадаадын түр оршин суугч бол Монгол Улсад түр оршин суугаа хаягийг бичнэ.	СБД, 1-р хороо, А хороолол, Б байр, 01 тоот	-
12.Утас	Харилцагч/үйлчлүүлэгчийн утасны дугаар (гэрийн утас, гар утас гэх мэт)	393939, 99000000	-
13.Эрхэлсэн ажил, мэргэжил, үйл ажиллагаа	Хувь хүн: Харилцагч/үйлчлүүлэгчийн эрхэлж буй ажил, мэргэжил, үйл ажиллагааг бичнэ. - Төрийн албан хаагч, төрийн өмчийн эсхүл хувийн компанийн ажилтан бол эрхэлж буй албан тушаал, хувиараа аж ахуй эрхэлдэг бол ямар чиглэлийн аж ахуй, бизнес эрхэлдэг, ажилгүй бол “ажилгүй” эсхүл тэтгэвэрт, оюутан, группд гэх мэтээр бичнэ. - Гадаадын иргэн бол Монголд эрхэлж буй ажил, албан тушаал, бизнесийн үйл ажиллагааг бичнэ.	ерөнхий захирал	-
14.Ажлын газрын нэр, хаяг, утас	Харилцагч/үйлчлүүлэгчийн ажлын газрын нэр, хаяг, холбоо барих утасны дугаар	АБВ Компани, СБД, 1-р хороо, А байр, А Корпус Утас: 333333	-

II. Б ХЭСЭГ. Харилцагч/үйлчлүүлэгч өөр хүний эсхүл байгууллагын нэрийн өмнөөс гүйлгээ хийж байгаа бол төлөөлүүлсэн хүн эсхүл байгууллагын мэдээллийг энэ хэсэгт бөглөнө.

Б ХЭСЭГ. Бусдаар төлөөлүүлэн гүйлгээ хийж байгаа этгээдийн мэдээлэл	Талбарын нэр	Тайлбар	Жишээ (Иргэн)	Жишээ (Хуулийн этгээд)
	15.Хувь хүн/ байгууллагын нэр	Хувь хүний нэр / Хуулийн этгээдийн нэр	Нарангэрэл	Эй Би Ви Жи ХХК
	16.Бусад нэр	Харилцагч/үйлчлүүлэгчид Талбар 15-д бичсэнээс өөр бусад нэр байдаг бол эсхүл өөр нэр ашигладаг бол түүнийг бичнэ.	Гэлэ	ABVG LLC
	17.Төрсөн улс	Хувь хүн: төрсөн улс Хуулийн этгээд: үүсгэн байгуулагдсан улс Улс орны нэрийг “СМА-нд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам”-ын Хавсралт 4-т байгаа ISO 3166-1 Улс, орнуудын нэр болон түүний товчилсон тэмдэгтийн стандартын дагуу бичнэ.	MN	MN
	18.Харьяалал	Хувь хүн: харьяалагдаж байгаа улс Улс орны нэрийг “СМА-нд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам”-ын Хавсралт 4-т байгаа ISO 3166-1 Улс, орнуудын нэр болон түүний товчилсон тэмдэгтийн стандартын дагуу бичнэ.	MN	-
	19.Төрсөн огноо	Хувь хүн: төрсөн огноо Хуулийн этгээд: үүсгэн байгуулагдсан огноо Огноог Майкрософт Эксел (Microsoft Excel)-ийн “Date” форматаар бичнэ.	1970/05/01	1970/05/01
	20.Биеийн байцаалтын төрөл (Гэрчилгээний төрөл)	Гүйлгээ хийх үед ашигласан бичиг баримтын төрөл	Иргэний үнэмлэх	Улсын бүртгэлийн гэрчилгээ
	21.Биеийн байцаалтын дугаар (Гэрчилгээний дугаар)	Гүйлгээ хийх үед ашигласан бичиг баримтын дугаар	УБ0123456	9268987422
	22.Ажил/ бизнес/ мэргэжил/ үйл ажиллагаа	Хувь хүн: Харилцагч/ үйлчлүүлэгчийн эрхэлж буй ажил, мэргэжил, үйл ажиллагааг бичнэ. - Төрийн албан хаагч, төрийн өмчийн эсхүл хувийн компанийн ажилтан бол эрхэлж буй албан тушаал, хувиараа аж ахуй эрхэлдэг	ерөнхий захирал	уул уурхай

	бол ямар чиглэлийн аж ахуй, бизнес эрхэлдэг, ажилгүй бол “ажилгүй” эсхүл тэтгэвэрт, оюутан, группд гэх мэтээр бичнэ. - Гадаадын иргэн бол Монголд эрхэлж буй ажил, албан тушаал, бизнесийн үйл ажиллагааг бичнэ. Хуулийн этгээд: Хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэл		
23.Ажлын газрын нэр, хаяг, утас	Харилцагч/үйлчлүүлэгчийн ажлын газрын нэр, хаяг, холбоо барих утасны дугаар	АБВ ХХК, СБД, 1-р хороо, А байр, А Корпус Утас: 333333	

III. В ХЭСЭГ. Энэ хэсэгт бэлнээр гарсан орлого болон зарлагын гүйлгээний дүн, төрөл, дансны талаарх мэдээллийг бичнэ.

В ХЭСЭГ. Гүйлгээ, дансны тухай мэдээлэл	Талбарын нэр	Тайлбар	Жишээ
	24.Гарсан гүйлгээний дүн*	20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээний мөнгөн дүн	100,000,000.00
	25.Орсон гүйлгээний дүн*		
	26.Гүйлгээ хийгдсэн огноо*	Бэлнээр хийсэн орлого болон зарлагын гүйлгээ хийгдсэн огноо Огноог Майкрософт Эксел (Microsoft Excel)-ийн “Date” форматаар бичнэ.	2019/09/01
	27.Валют*	Валютыг “СМА-нд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам”-ын Хавсралт 5-д байгаа ISO 4217 Улс, орнуудын мөнгөн тэмдэгтийн нэр болон түүний товчилсон тэмдэгтийн стандартын дагуу бичнэ.	MNT
	28.Дансны дугаар	Гүйлгээнд холбогдох дансны дугаар	500400300100
	29.Гүйлгээний төрөл	Гүйлгээний төрөл	компани худалдан авах
	30.Данс эзэмшигчийн бүтэн нэр	Энэ маягтын Талбар 28-д заасан дансны дугаар эзэмшигчийн бүтэн нэр	Доржийн Бат эсхүл АБВГД ХХК
	31.Хаяг	Хувь хүн: Харилцагч/үйлчлүүлэгчийн оршин суугаа хаягийг бичих ба гадаадын түр оршин суугч бол Монгол Улсад түр оршин суугаа хаягийг бичнэ. Хуулийн этгээд: Хуулийн этгээдийн оршин байгаа газрын албан ёсны хаяг	СБД, 1-р хороо, А хороолол, Б байр, 01 тоот
	32.Утас	Харилцагч/үйлчлүүлэгчийн утасны дугаар (гэрийн утас, гар утас гэх мэт)	393939, 99000000

IV. Г ХЭСЭГ. Энэ хэсэгт 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний орлого хүлээн авч буй хүлээн авагч (нөгөө тал)-ийн талаарх мэдээллийг бөглөнө.

Г ХЭСЭГ. Гүйлгээнд оролцогч нөгөө талын мэдээлэл	Талбарын нэр	Тайлбар	Жишээ (Иргэн)	Жишээ (Хуулийн этгээд)
	33.Хүлээн авагч/ Шилжүүлэгчийн нэр	Хувь хүний нэр /Хуулийн этгээдийн нэр	Болд	ДГВБА ХХК
	34.Утас	Талбар 33-т бичигдсэн хувь хүн / хуулийн этгээдийн утасны дугаар (гэрийн утас, гар утас, ажлын утас гэх мэт)	393939, 99000000	494949, 77110001
	35.Хүлээн авагч/ Шилжүүлэгчийн хаяг	Хувь хүн: Талбар 33-т бичигдсэн хувь хүний оршин суугаа хаягийг бичих ба гадаадын түр оршин суугч бол Монгол Улсад түр оршин суугаа хаягийг бичнэ. Хуулийн этгээд: Талбар 33-т бичигдсэн хуулийн этгээдийн оршин байгаа газрын албан ёсны хаяг	СБД, 1-р хороо, А хороолол, Б байр, 01 тоот	БЗД, 1 хороо, Улаанбаатар тауер 5-345 тоот
	36.Гүйлгээний утга	Гүйлгээний утга	компани худалдан авах	компани худалдан авах
	37. Гүйлгээнд оролцогч нөгөө талын дансны дугаар	Гүйлгээнд холбогдох нөгөө талын дансны дугаар	50040030010 0	456465465465 4564654
	38.Хүлээн авагч/ Шилжүүлэгчийн банк	Гүйлгээнд холбогдох банкны нэр	Гэрэл банк	Гэрэл банк

V. Д ХЭСЭГ. Энэ хэсэгт Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан бэлтгэж ирүүлсэн мэдээлэх үүрэгтэй этгээд буюу Хуульчийн талаарх мэдээллийг бичнэ.

Д ХЭСЭГ. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн талаарх мэдээлэл	Талбарын нэр	Тайлбар	Жишээ
	39.Мэдээлэх үүрэгтэй этгээдийн нэр*	Гүйлгээг мэдээлж байгаа хуульчийн нэрийг бичнэ.	Нарансаран.Г
	40.Хаяг*	Мэдээлэх үүрэгтэй этгээдийн төрлийг бичнэ	Хуульч
	41.Гэрчилгээний дугаар*	Хуульчийн гэрчилгээний дугаар (Тамганы дугаар)	123456789
	42.Энэхүү тайланг бэлтгэсэн ажилтны овог, нэр*	Энэ маягтын Талбар 39-д заасан Мэдээлэх үүрэгтэй этгээдийн нэртэй ижил бичнэ.	Нарансаран.Г
	43.Албан тушаал*	Энэ маягтын Талбар 40-д заасан Мэдээлэх үүрэгтэй этгээдийн төрөлтэй ижил бичнэ.	Хуульч
44. Тайланг хянасан ажилтны овог, нэр*	Энэ маягтын Талбар 39-д заасан Мэдээлэх үүрэгтэй этгээдийн нэртэй ижил бичнэ.	Нарансаран.Г	

45.Албан тушаал*	Энэ маягтын Талбар 40-д заасан Мэдээлэх үүрэгтэй этгээдийн төрөлтэй ижил бичнэ.	Хуульч
46.Холбоо барих утас*	Мэдээлэх үүрэгтэй этгээдтэй холбоо барих утас, дотуур утасны дугаар	333333 (123)
47.Э-мэйл хаяг*	Мэдээлэх үүрэгтэй этгээдийн и-мэйл хаяг	tsetsgee@abank.mn
48.Тайланг илгээсэн огноо*	Огноог Майкрософт Эксел (Microsoft Excel)-ийн "Date" форматаар бичнэ.	2020/01/01

ТАЙЛБАР: Бэлэн мөнгөний гүйлгээний тайлангийн маягт дахь * тэмдэглэгээтэй талбарыг заавал бөглөх шаардлагатай. Хэрэв хуульчид *-оор тэмдэглэснээс бусад талбарын мэдээлэл байгаа бол тухайн мэдээллийг бүрэн бөглөж, байхгүй бол хоосон орхино.

ЗААВАР 3. ГАДААД ТӨЛБӨР ТООЦООНЫ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН БӨГЛӨХ

Хуульч нь энэ заавар, зөвлөмжийн 2.1-д дурдсан ажиллагааг хийх явцдаа харилцагч/үйлчлүүлэгчтэй холбоотой 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй гадаад төлбөр тооцооны гүйлгээ хийсэн бол дараах зааврын дагуу Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлангийн маягтыг бөглөж СМА-д хүргүүлнэ.

I. А ХЭСЭГ. Энэ хэсэгт 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй гадаад төлбөр тооцооны гүйлгээг шилжүүлсэн харилцагч/үйлчлүүлэгчийн мэдээллийг бөглөнө.

Хэрэв харилцагч/үйлчлүүлэгч өөрийн нэрээр гүйлгээ шилжүүлж байгаа бол зөвхөн 1-12 талбарт түүний мэдээллийг бөглөнө. Харин харилцагч/үйлчлүүлэгч өөр хүний эсхүл байгууллагын нэрийн өмнөөс гүйлгээ шилжүүлж байгаа бол түүний мэдээллийг 13-15 талбарт, төлөөлүүлсэн этгээд (иргэн эсхүл хуулийн этгээд)-ийн мэдээллийг 1-12 талбарт тус тус бөглөнө.

А ХЭСЭГ. Гуйвуулагч байгууллага, хувь хүний галларх мэдээлэл	Талбарын нэр	Тайлбар	Жишээ (Иргэн)	Жишээ (Хуулийн этгээд)
	1.Эцгийн нэр	Эцгийн нэр	Дорж	-
	2.Өөрийн нэр/ Байгууллагын нэр*	Хувь хүний нэр / Хуулийн этгээдийн нэр	Бат	Эй Би Ви Жи ХХК
	3.Ургийн овог	Ургийн овог	Боржигон	-
	4.Харьяалал	Хувь хүн: харьяалагдаж байгаа улс Улс орны нэрийг “СМА-нд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам”-ын Хавсралт 4-т байгаа ISO 3166-1 Улс, орнуудын нэр болон түүний товчилсон тэмдэгтийн стандартын дагуу бичнэ.	MN	MN
	5.Төрсөн огноо	Хувь хүн: төрсөн огноо Хуулийн этгээд: үүсгэн байгуулагдсан огноо Огноог Майкрософт Эксел (Microsoft Excel)-ийн “Date” форматаар бичнэ.	1970/05/01	1992/05/01
	6.Бичиг баримтын төрөл	Гүйлгээ хийх үед ашигласан бичиг баримтын төрөл	Иргэний үнэмлэх	Улсын бүртгэлийн гэрчилгээ
	7.Бичиг баримтын дугаар	Гүйлгээ хийх үед ашигласан бичиг баримтын дугаар	УБ0123456	9268987422
	8.Регистрийн дугаар*	Хувь хүн: Харилцагч/үйлчлүүлэгч нь Монгол Улсын иргэн бол түүний регистрийн дугаарыг, гадаадын иргэн бол түүний бичиг баримт дээрх регистрийн дугаар эсхүл бусад ижил төстэй дугаарыг бичнэ. Хуулийн этгээд: Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд бол түүний регистрийн дугаарыг, гадаад улсын	АБ70050100	5897635

	хуулийн этгээд бол түүний бичиг баримт дээрх регистрийн дугаар эсхүл бусад ижил төстэй дугаарыг бичнэ.		
9. Оршин суугаа хаяг	Хувь хүн: Харилцагч/үйлчлүүлэгчийн оршин суугаа хаягийг бичих ба гадаадын түр оршин суугч бол Монгол Улсад түр оршин суугаа хаягийг бичнэ. Хуулийн этгээд: Хуулийн этгээдийн оршин байгаа газрын албан ёсны хаяг	СБД, 1-р хороо, А хороолол, Б байр, 01 тоот	БЗД, 1 хороо, Улаанбаатар тауер 1-300 тоот
10. Холбоо барих утас	Харилцагч/үйлчлүүлэгчийн утасны дугаар (гэрийн утас, гар утас, ажлын утас гэх мэт)	393939, 99000000	494949, 77110000
11. Эрхэлдэг ажил, бизнесийн үйл ажиллагаа эсхүл албан тушаал	Хувь хүн: Харилцагч/үйлчлүүлэгчийн эрхэлж буй ажил, мэргэжил, үйл ажиллагааг бичнэ. - Төрийн албан хаагч, төрийн өмчийн эсхүл хувийн компанийн ажилтан бол эрхэлж буй албан тушаал, хувиараа аж ахуй эрхэлдэг бол ямар чиглэлийн аж ахуй, бизнес эрхэлдэг, ажилгүй бол “ажилгүй” эсхүл тэтгэвэрт, оюутан, группд гэх мэтээр бичнэ. - Гадаадын иргэн бол Монголд эрхэлж буй ажил, албан тушаал, бизнесийн үйл ажиллагааг бичнэ. Хуулийн этгээд: Хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэл	ерөнхий захирал	уул уурхай
12. Ажлын газрын нэр, хаяг, утас	Хувь хүн бол түүний ажилладаг байгууллага/компанийн, харин байгууллага, ААН бол түүний нэр, хаяг, холбоо барих утасны дугаарыг бичнэ.	АБВ Компани, СБД, 1-р хороо, А байр, А Корпус Утас: 333333	-
13. Гүйлгээг өөр хүн /итгэмжлэгдс эн төлөөлөгч/ хийсэн бол түүний Овог нэр	Энэ талбарт А хэсгийн 1-12-т дурдсан этгээдийг төлөөлж буй иргэний мэдээллийг бөглөнө. Хэрэв иргэн хэн нэгнийг төлөөлөөгүй тохиолдолд эсхүл 1-12-т бичигдсэн этгээд хэн нэгнээр төлөөлүүлээгүй тохиолдолд зөвхөн А хэсгийн 1-12 талбарыг бөглөнө.	Бамбарын Зулзага	-
14. Бичиг баримтын дугаар	Талбар 13-т бичигдсэн хүний гүйлгээ хийх үед ашигласан иргэний үнэмлэх, гадаад паспорт зэрэг холбогдох журамд нийцсэн биеийн байцаалтын дугаар Харилцагч нь Монгол Улсын иргэн бол түүний регистрийн дугаарыг, гадаадын иргэн бол түүний бичиг	НЭ01121212	-

		баримтан дээрх регистрийн дугаар эсхүл бусад ижил төстэй дугаарыг бичиж болно.		
	15. Эрхэлдэг ажил, бизнесийн үйл ажиллагаа эсхүл албан тушаал	Талбар 13-т бичигдсэн хүний эрхэлж буй ажил, мэргэжил, үйл ажиллагааг бичнэ. - Төрийн албан хаагч, төрийн өмчийн эсхүл хувийн компанийн ажилтан бол эрхэлж буй албан тушаал, хувиараа аж ахуй эрхэлдэг бол ямар чиглэлийн аж ахуй, бизнес эрхэлдэг, ажилгүй бол “ажилгүй” бөгөөд тэтгэвэрт, оюутан, группэд гэх мэтээр бичнэ. - Гадаадын иргэн бол Монголд эрхэлж буй ажил, албан тушаал, бизнесийн үйл ажиллагааг бичнэ.	АБВ Компанийн ерөнхий ня-бо	-

II. Б ХЭСЭГ. Энэ хэсэгт гадаад төлбөр тооцооны гүйлгээг хүлээн авагч хувь хүн, хуулийн этгээдийн талаарх мэдээллийг бөглөнө. Хэрэв хүлээн авагч өөрийн нэр дээр гүйлгээг хүлээн авч байгаа бол зөвхөн 16-27 талбарыг бөглөнө. Харин харилцагч/үйлчлүүлэгч өөр хүний эсхүл байгууллагын нэрийн өмнөөс гүйлгээ хүлээн авч байгаа бол түүний мэдээллийг 28-30 талбарт, төлөөлүүлсэн этгээдийн мэдээллийг 16-27 талбарт тус тус бөглөнө.

Б ХЭСЭГ. Хүлээн авагч байгууллага, хувь хүний талаарх мэдээлэл	Талбарын нэр	Тайлбар	Жишээ (Иргэн)	Жишээ (Хуулийн этгээд)
	16.Эцгийн нэр	Эцгийн нэр	Батаа	-
	17.Өөрийн нэр/ Байгууллагын нэр*	Хувь хүний нэр/Хуулийн этгээдийн нэр	Дондов	Жи Эй Би Ви Жи ХХК
	18.Ургийн овог	Ургийн овог	Боржигон	-
	19.Харьяалал	Хувь хүн: харьяалагдаж байгаа улс Улс орны нэрийг “СМА-нд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам”-ын Хавсралт 4-т байгаа ISO 3166-1 Улс, орнуудын нэр болон түүний товчилсон гэмдэгтийн стандартын дагуу бичнэ.	MN	MN
	20.Төрсөн огноо	Хувь хүн: төрсөн огноо Хуулийн этгээд: үүсгэн байгуулагдсан огноо Огноог Майкрософт Эксел (Microsoft Excel)-ийн “Date” форматаар бичнэ.	1980/05/01	2002/05/01
	21.Бичиг баримтын төрөл	Гүйлгээ хийх үед ашигласан бичиг баримтын төрөл	Иргэний үнэмлэх	Улсын бүртгэлийн гэрчилгээ
	22.Бичиг баримтын дугаар	Гүйлгээ хийх үед ашигласан бичиг баримтын дугаар	УБ0124444	92689872
23.Регистрийн	Хувь хүн: Харилцагч/үйлчлүүлэгч нь	АБ98855100	5891214	

дугаар	Монгол Улсын иргэн бол түүний регистрийн дугаарыг, гадаадын иргэн бол түүний бичиг баримт дээрх регистрийн дугаар эсхүл бусад ижил төстэй дугаарыг бичнэ. Хуулийн этгээд: Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд бол түүний регистрийн дугаарыг, гадаад улсын хуулийн этгээд бол түүний бичиг баримт дээрх регистрийн дугаар эсхүл бусад ижил төстэй дугаарыг бичнэ.		
24.Оршин суугаа хаяг	Хувь хүн: Харилцагч/үйлчлүүлэгчийн оршин суугаа хаягийг бичих ба гадаадын түр оршин суугч бол Монгол Улсад түр оршин суугаа хаягийг бичнэ. Хуулийн этгээд: Хуулийн этгээдийн оршин байгаа газрын албан ёсны хаяг	СБД, 58-р хороо, Б хороолол, 45 байр, 01 тоот	БЗД, 15 хороо, Улаанбаатар тауер 4-30 тоот
25.Холбоо барих утас	Харилцагч/үйлчлүүлэгчийн утасны дугаар (гэрийн утас, гар утас, ажлын утас гэх мэт)	393939, 99111111	494444, 88110000
26.Эрхэлдэг ажил, бизнесийн үйл ажиллагаа эсхүл албан тушаал	Хувь хүн: Харилцагч/үйлчлүүлэгчийн эрхэлж буй ажил, мэргэжил, үйл ажиллагааг бичнэ. - Төрийн албан хаагч, төрийн өмчийн эсхүл хувийн компанийн ажилтан бол эрхэлж буй албан тушаал, хувиараа аж ахуй эрхэлдэг бол ямар чиглэлийн аж ахуй, бизнес эрхэлдэг, ажилгүй бол “ажилгүй” эсхүл тэтгэвэрт, оюутан, группд гэх мэтээр бичнэ. - Гадаадын иргэн бол Монголд эрхэлж буй ажил, албан тушаал, бизнесийн үйл ажиллагааг бичнэ. Хуулийн этгээд: Хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэл	ерөнхий захирал	уул уурхай
27.Ажлын газрын нэр, хаяг, утас	Хувь хүн бол түүний ажилладаг байгууллага/компанийн, харин байгууллага, ААН бол түүний нэр, хаяг, холбоо барих утасны дугаарыг бичнэ.	ВГДЕ Компани, СБД, 16-р хороо, Б байр, А Корпус Утас: 444444	-
28. Гүйлгээг өөр хүн /итгэмжлэгдсэн төлөөлөгч/ хийсэн бол түүний Овог нэр	Энэ талбарт Б хэсгийн 16-27-д дурдсан этгээдийг төлөөлж буй иргэний мэдээллийг бөглөнө. Хэрэв иргэн хэн нэгнийг төлөөлөөгүй тохиолдолд эсхүл 16-27-д бичигдсэн этгээд хэн нэгнээр төлөөлүүлээгүй тохиолдолд зөвхөн Б хэсгийн 16-27	Арслангийн Гүен	-

		талбарыг бөглөнө.		
	29.Бичиг баримтын дугаар	Талбар 28-т бичигдсэн хүний гүйлгээ хийх үед ашигласан иргэний үнэмлэх, гадаад паспорт зэрэг холбогдох журамд нийцсэн биеийн байцаалтын дугаар Харилцагч/үйлчлүүлэгч нь Монгол Улсын иргэн бол түүний регистрийн дугаарыг, гадаадын иргэн бол түүний бичиг баримтан дээрх регистрийн дугаар эсхүл бусад ижил төстэй дугаарыг бичиж болно.	НЭ78787878	-
	30.Эрхэлдэг ажил, бизнесийн үйл ажиллагаа эсхүл албан тушаал	Талбар 28-т бичигдсэн хүний эрхэлж буй ажил, мэргэжил, үйл ажиллагааг бичнэ. - Төрийн албан хаагч, төрийн өмчийн эсхүл хувийн компанийн ажилтан бол эрхэлж буй албан тушаал, хувиараа аж ахуй эрхэлдэг бол ямар чиглэлийн аж ахуй, бизнес эрхэлдэг, ажилгүй бол “ажилгүй” бөгөөд тэтгэвэрт, оюутан, группэд гэх мэтээр бичнэ. - Гадаадын иргэн бол Монголд эрхэлж буй ажил, албан тушаал, бизнесийн үйл ажиллагааг бичнэ.	Жи Эй Би Ви Жи ХХК-ийн ерөнхий ня-бо	-

III. В ХЭСЭГ. Энэ хэсэгт гадаад төлбөр тооцооны гүйлгээний дүн, төрөл, данс, шилжүүлсэн болон хүлээн авсан банкны талаарх мэдээллийг бичнэ.

	Талбарын нэр	Тайлбар	Жишээ
В ХЭСЭГ. Гүйлгээний талаарх мэдээлэл	31.Гүйлгээ хийгдсэн огноо*	Гадаад төлбөр тооцооны гүйлгээ хийгдсэн огноо Огноог Майкрософт Эксел (Microsoft Excel)-ийн “Date” форматаар бичнэ.	2019/09/01
	32.Гарсан гүйлгээний дүн	Гадаад төлбөр тооцооны гарсан гүйлгээний дүн буюу Монгол Улсаас гадаад улс руу хийж байгаа гадаад төлбөр тооцооны гүйлгээний дүн. Төгрөгөөр хийгдсэн гүйлгээг тэр дүнгээр нь, гадаад валютаар хийгдсэн гүйлгээний дүнг тухайн валютын дүнгээр (төгрөгт шилжүүлэхгүйгээр) бичих ба “34. Валютын нэгж” талбарт ямар валют гэдгийг бичнэ. Тухайлбал, харилцагч/үйлчлүүлэгч 20,000 ам.доллар гадаад улсруу шилжүүлсэн бол 32 дахь талбарт 20,000, 34 дэх талбарт USD гэж бичнэ.	150,000.21
	33.Орсон гүйлгээний дүн	Гадаад төлбөр тооцооны орсон гүйлгээний дүн буюу гадаад улсаас Монгол Улс руу хүлээн авч байгаа гадаад төлбөр тооцооны дүн. Төгрөгөөр хийгдсэн гүйлгээг тэр дүнгээр нь, гадаад валютаар хийгдсэн гүйлгээний дүнг тухайн валютын дүнгээр (төгрөгт шилжүүлэхгүйгээр) бичих ба “34. Валют” талбарт	20.000

	ямар валют гэдгийг бичнэ. Тухайлбал, харилцагч/үйлчлүүлэгч 20,000 ам.долларын гүйлгээ гадаад улсаас хүлээн авсан бол 33 дахь талбарт 20,000, 34 дэх талбарт USD гэж бичнэ.	
34.Валютын нэгж*	Валютын нэгжийг “СМА-нд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам”-ын Хавсралт 5-д байгаа ISO 4217 Улс, орнуудын мөнгөн тэмдэгтийн нэр болон түүний товчилсон тэмдэгтийн стандартын дагуу бичнэ.	USD
35.Гүйлгээний утга / Төлбөрийн зориулалт*	Гүйлгээний утга	компани худалдан авах
36.Гүйлгээ хийсэн буюу төлбөр шилжүүлсэн банкны код	Шилжүүлэгчийн гүйлгээ хийсэн банкны кодыг бичнэ.	AAMNUB
37.Гүйлгээ хийсэн буюу төлбөр шилжүүлсэн банкны нэр	Шилжүүлэгчийн данс байршиж байгаа банкны нэр	Aaa bank
38.Гүйлгээ хийсэн буюу төлбөр шилжүүлсэн банкны хаяг	Шилжүүлэгчийн данс байршиж байгаа банкны хаяг	СБД, 1-р хороо, А байр, А Корпус
39.Гүйлгээ хийгдсэн дансны дугаар	Шилжүүлэгчийн дансны дугаар	10123012212
40.Гүйлгээг хүлээн авсан банкны код	Гүйлгээ хүлээн авсан банкны кодыг бичнэ.	HSBCUS
41.Гүйлгээг хүлээн авсан банкны нэр	Гүйлгээ хүлээн авсан банкны нэр	HSBC Банк
42.Гүйлгээг хүлээн авсан банкны хаяг	Гүйлгээ хүлээн авсан банкны хаяг	Merlon str, Carlton, CA US
43.Гүйлгээг хүлээн авсан банкны дансны дугаар	Гүйлгээ хүлээн авагчийн дансны дугаар	12121321321

IV. Г ХЭСЭГ. Энэ хэсэгт гадаад төлбөр тооцооны гүйлгээг дамжуулж байгаа корреспондент банкны мэдээллийг бичнэ.

Г ХЭСЭГ. Гүйлгээгэй холбоотой нэмэлт мэдээлэл	Талбарын нэр	Тайлбар	Жишээ
	44.Төлбөр гүйцэтгэгчийн корреспондент банкны нэр	Гүйлгээ дамжуулсан төлбөр гүйцэтгэгчийн корреспондент банкны нэр	HSBC
	45.Төлбөр гүйцэтгэгчийн корреспондент банкны оршин байгаа хот, улс	Гүйлгээ дамжуулсан төлбөр гүйцэтгэгчийн корреспондент банкны хаяг	21 Huang str, Hong Kong, China
	46.Хүлээн авагчийн корреспондент банкны нэр	Гүйлгээ дамжуулсан төлбөр хүлээн авагчийн корреспондент банкны нэр	Commerzbank
	47.Хүлээн авагчийн корреспондент банкны оршин байгаа хот, улс	Гүйлгээ дамжуулсан төлбөр хүлээн авагчийн корреспондент банкны хаяг	545 Bitter str, Frankfurt, Germany
	48.Шилжүүлэгчээс хүлээн авагчид дамжуулсан мэдээлэл	Гүйлгээ дамжуулсан төлбөр хүлээн авагчийн корреспондент банкны дамжуулсан мэдээлэл	/RPP/321.130124.6.E LEK.01 /DAS/130124.130124 .000000

V. Д ХЭСЭГ. Энэ хэсэгт Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайланг бэлтгэж ирүүлсэн мэдээлэх үүрэгтэй этгээд буюу Хуульчийн талаарх мэдээллийг бичнэ.

Д ХЭСЭГ. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн талаарх мэдээлэл	Талбарын нэр	Тайлбар	Жишээ
	49.Мэдээлэх үүрэгтэй этгээдийн нэр*	Гүйлгээг мэдээлж байгаа хуульчийн нэрийг бичнэ.	Нарансаран.Г
	50.Хаяг*	Мэдээлэх үүрэгтэй этгээдийн төрлийг бичнэ	Хуульч
	51.Гэрчилгээний дугаар*	Хуульчийн гэрчилгээний дугаар (Тамганы дугаар)	123456789
	52.Энэхүү тайланг бэлтгэсэн ажилтны овог, нэр*	Энэ маягтын Талбар 49-д заасан Мэдээлэх үүрэгтэй этгээдийн нэртэй ижил бичнэ	Нарансаран.Г
	53.Албан тушаал*	Энэ маягтын Талбар 50-д заасан Мэдээлэх үүрэгтэй этгээдийн төрөлтэй ижил бичнэ	Хуульч
	54.Тайланг хянасан ажилтны овог, нэр*	Энэ маягтын Талбар 49-д заасан Мэдээлэх үүрэгтэй этгээдийн нэртэй ижил бичнэ	Нарансаран.Г
	55.Албан тушаал*	Энэ маягтын Талбар 50-д заасан Мэдээлэх үүрэгтэй этгээдийн төрөлтэй ижил бичнэ	Хуульч
	56.Холбоо барих утас*	Мэдээлэх үүрэгтэй этгээдтэй холбоо барих утас, дотуур утасны дугаар	333333 (123)
	57.Э-мэйл хаяг*	Мэдээлэх үүрэгтэй этгээдийн и-мэйл хаяг	tsetsgee@abank.mn
58.Тайланг бэлтгэсэн огноо*	Огноог Майкрософт Эксел (Microsoft Excel)-ийн "Date" форматаар бичнэ.	2020/01/01	

ТАЙЛБАР: Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлангийн маягт дахь * тэмдэглэгээтэй талбарыг заавал бөглөх шаардлагатай. Хэрэв хуульчид *-оор тэмдэглэснээс бусад талбарын мэдээлэл байгаа бол тухайн мэдээллийг бүрэн бөглөж, байхгүй бол хоосон орхино.

_____oO_____